


АГУУЛГА

1. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт.....	2
2. Автотээврийн үндсэн үзүүлэлт.....	4
3. Автотээврийн салбарын зорчигч тээвэрлэлт.....	5
4. Улс хоорондын ачаа тээвэрлэлт	10
5. Тээврийн хэрэгслийн бүртгэл.....	13
6. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг	17
7. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх.....	18
8. Автоүйлчилгээ.....	20
9. Зам тээврийн осол, зөрчил.....	20
10. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал.....	21
11. Хавсралт.....	22


1. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын тээвэр нь авто тээвэр, төмөр замын тээвэр, агаарын тээвэр, усан замын тээвэр гэсэн төрлөөс бүрдэнэ.

Тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлтэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, тээврийн орлого гэсэн үзүүлэлтүүд орно.




Ачаа эргэлт - нэг тонн ачаа нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.



Тээсэн ачаа – Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.


Бүх төрлийн тээврээр 2017 онд 53.9 сая.тн ачаа, давхардсан тоогоор 215.7 сая.хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 13.5 сая.тн буюу 33.5%-аар өсөж, харин зорчигчдын тоо 48.3 сая.хүн буюу 18.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт тээвэрлэсэн зорчигчдын 98.8 хувь, нийт тээсэн ачааны 57.8 хувийг автотээврээр гүйцэтгэсэн байна.



Зорчигч эргэлт – нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.


Бүх төрлийн тээврийн орлого 2017 онд 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 166.9 тэрбум төгрөг буюу 14%-аар өссөн байна.



2. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ачаа зорчигч тээврийн үйлчилгээ:

Автотээвэрээр 2017 онд 31.2 сая.тн ачаа, давхардсан тоогоор 212.2 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 10.8 сая.тн буюу 53.0%-аар өсөж, харин зорчигч тээвэрлэлт 48.5 сая.хүн буюу 18.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.



2.2. Авто тээврийн орлого:

Авто тээврийн орлого 2017 онд 506.4 тэрбум төгрөг хүрч, өмнөх оноос 39.7 тэрбум төгрөг буюу 8.5%-аар өссөн байна.



Тээврийн орлого – тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болж авч байгаа өртгийн нийлбэр. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого.


Авто тээврийн салбарын орлого 2015 оноос өсөхөд нүүрсний тээвэрлэлт голчлон нөлөөлсөн байна. Сүүлийн жилүүдэд авто замын дэд бүтэц, уул уурхайн тээвэрлэлтийн өсөлтийг дагаад автотээврийн салбарын эдийн засгийн үзүүлэлт тогтмол нэмэгдсэн байна.

3. АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Автотээврийн салбар 2016 онд 260.6 сая зорчигч тээвэрлэж, 1959.9 сая хүн.км-ийн ажил гүйцэтгэж байсан бол, 2017 онд 212.2 сая зорчигч тээвэрлэж зорчигчдын тоо өмнөх оноос 48.5 сая.хүн буюу 18.6%-иар буурч, зорчигч эргэлт 81 сая хүн.км-ээр буюу 4%-иар өссөн байна.

Зорчигч тээврийн үйлчилгээг орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэж байна. Улс, хот хооронд, орон нутгийн тээврийн үйлчилгээг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Улаанбаатар хот болон хот орчмын тээврийн үйлчилгээг Нийслэлийн тээврийн газар зохион байгуулж байна.


2017 оны байдлаар улс хоорондын 10 чиглэлд 13 аж ахуйн нэгж байгууллага, хот хоорондын 80 чиглэлд 50 аж ахуйн нэгж, байгууллага үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс хот хооронд 2.4 сая зорчигч, улс хооронд 118 мянган зорчигч, орон нутагт 13.5 мянган зорчигч тус тус тээвэрлэсэн.



3.1. Хот доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ

2017 онд хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээг 39 аж ахуйн нэгж, байгууллага эрхлэн явуулж нийт 196 сая зорчигч тээвэрлэсэн байна.

Зорчигч эргэлт 667.1 сая хүн.км болж, өмнөх оноос зорчигчийн тоо 48,1 сая.хүн буюу 19.6 %-иар, зорчигч эргэлт 163.5 сая хүн.км буюу 19.4 %-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үүнд автобусны төлбөрийн системийг цахимд шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.



Хот доторх болон хот орчмын нийтийн тээвэр


Нийтийн тээврийн үйлчилгээнд хөлс төлөлтийг цахим системд шилжүүлж, хотын гудамж, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, чиглэлүүдийн давхцалыг багасгах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээний шинэчилсэн төлөвлөлтийг 2015 оны 8-р сарын 15-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Хөлс төлөлтийг цахим хэлбэрт шилжүүлснээр зорчих тасалбар таслахгүйгээр кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлсэн нь зорчигчдын хөлс төлөлтөнд тавих хяналтыг сулруулсан.

Чиглэл мартшрутын шинэчилсэн төлөвлөлтийн хүрээнд зүүн гарын эргэлт болон чиглэл маршрутын давхцалыг бууруулах үүднээс зарим чиглэлүүдийг богино эргэлтээр эргүүлэх болсон, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор шаардлагатай зорчигч урсгалын төвлөрөл, цэгүүдэд зогсоол буудлыг шийдэж өгч чадахгүйгээс иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих эрэлтийг хангаж чадахгүй, иргэд хувийн унааг унах сонирхолыг төрүүлсэн нь мөн зорчигчийн тоо буурахад нөлөөлж байна.

3.2. Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ

Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг 50 аж ахуйн нэгж байгууллага 80 чиглэлд 971 тээврийн хэрэгсэл, 1215 мэргэшсэн жолоочтойгоор гүйцэтгэж байна. 2017 онд 2,401.8 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.0%-иар өссөн үзүүлэлттэй байна.




Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 190 дугаар тушаалаар Хот хоорондын нийтийн тээврийн 85 чиглэлийн зураглалыг баталсан. Уг тушаалын дагуу хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэл бүрд хувийн хэрэг нээх, аяллын дугаар олгох зорилгоор 3 баг давхардсан тоогоор 70 хоногийн туршид чиглэлүүдийн дагуу үзлэг хийж, чиглэлийн хувийн хэрэг хөтлөх ажлыг эхлүүлэхээр хуваарийн дагуу ажиллаж байна.

3.3. Улс хоорондын байнгын зорчигч тээврийн үйлчилгээ


Улс хоорондын байнгын зорчигч тээвэрлэлтийг 3 улсын 10 чиглэлд 13 аж ахуйн нэгж байгууллага 91 тээврийн хэрэгсэл, 112 мэргэшсэн жолоочтойгоор гүйцэтгэж байна.

2017 онд 188,1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10%-иар өссөн үзүүлэлттэй байна.



Улс хоорондын байнгын зорчигч тээврийн үйлчилгээ

Замын-Үүд-Эрээн хот хооронд 2017 онд тээвэрлэсэн зорчигчдын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад “АТҮТ” ТӨҮГ-ийн автобусаар тээвэрлэсэн зорчигч 59 526 байгаа нь 19,8%-иар, “Дэлгэрэх тээх” ХХК-ний автобусаар тээвэрлэсэн зорчигч 57 667 байгаа нь 30,4%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Замын-Үүд – Бээжин хот чиглэлд улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж буй “Жиу Лун Сян Хө” ХХК нь 2017 онд 11 541 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2,3%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Бээжин, Хөх хотын чиглэлд 2014 оноос зорчигч урсгал нь эрс нэмэгдсэн байна. Учир нь 2012, 2013 онуудад тус чиглэлүүдэд туршилтын журмаар явуулж байгаад 2014 оноос тээвэрлэлтийг тогтмол болгон гүйцэтгэж байна.




Замын-Үүд –Хөх хот чиглэлд улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж буй “Юань Шүнь” ХХК нь 2017 онд 8 101 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16,7%-иар өссөн үзүүлэлттэй байна.



Улаанбаатар-Улаан-Үүд чиглэлд 2017 онд тээвэрлэсэн зорчигчдын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Нью жуулчин турс” ХХК 1,0%-иар, “Восток транс” ХХК 4,7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




Өлгий – Караганда чиглэлд улс хоорондын байнгын зорчигч тээврийн үйлчилгээ 2014 онд эхэлсэн бөгөөд БНКаЗУ-ын талаас “АБИ” ХХК, Монгол Улсын талаас “Цэнгэл транс” ХХК тээвэрлэлт гүйцэтгэж байна. 2017 онд 6145 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 69,9%-иар өссөн үзүүлэлттэй байна.



4. УЛС ХООРОНДЫН АЧАА ТЭЭВЭР

2017 онд улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгүүлэх гэрээг 3 хүртэлх жилийн хугацаатай 10 чиглэлд 241 аж ахуйн нэгж, байгууллага тээвэрлэлтийн гэрээ байгуулан 11125 хүнд даацын автомашин, 9004 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэсэн байна.



СТҮХ-оос авсан мэдээлэл


Улс хооронд 2017 онд 33,1 сая.тн ачаа тээвэрлэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 20,0%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлт нь нүүрсний олборлолт сэргэж, ашигт малтмалын экспортын гүйцэтгэл өссөн байсантай холбоотой.



Хилийн боомтоор нэвтэрсэн барааны эзлэх хэмжээг авч үзвэл: импортын бараа 790.63 мян.тн нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 30%-иар буурсан, экспортын бүтээгдэхүүн 32,3 сая.тн тээвэрлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22,8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнд нүүрс тээвэрлэлт өмнөх оны мөн үеэс 5.3 сая тонноор, төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ өсөж тээвэрлэлтийн хэмжээ 8 дахин тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Экспортын голлох бүтээгдэхүүнүүд 2017 онд нүүрс 29.6 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-иар, төмрийн хүдэр 1,150.6 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8 дахин тус тус өссөн бол зэсийн баяжмал 652.1 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 24.8%-иар, газрын тос 859.9 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 10%-иар нь тус тус буурсан үзүүлэлттэй байна.



АТҮТ-өөс авсан мэдээлэл



Улс хоорондын ачаа тээвэрт зонхилох ачаа нь уул уурхай, ашигт малтмалын тээвэрлэлт бөгөөд тухайн тээвэрлэлт нь Монгол Улсын Дорнод аймгийн Баянхошуу боомтоор тоног төхөөрөмж, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтоор газрын тос, нүүрс, Дорноговь аймгийн Замын-Үүд боомтоор бүх төрлийн барилгын материал, тоног төхөөрөмж, уул уурхай ашигт малтмалын тээвэрлэлт, Ханги боомтоор нүүрс, төмрийн хүдэр, Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтуудаар нүүрс, зэсийн баяжмал, тоног төхөөрөмж, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор төмрийн хүдэр, Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтоор нүүрс тээвэрлэлт хийгдэж байна.

АВТОЗАМЫН ХИЛИЙН БООМТООР НЭВТЭРСЭН АЧААНЫ СУДАЛГАА

№	Боомтын нэр	Нэр төрөл	Экспорт /мян.тн/
1	Бичигт	Газрын тос	388.081
		Хүрэн нүүрс	309.046
		Хүдэр	26.910
		Жонс	311
2	Баянхошуу	Газрын тос	471.891
		Жонш	610
3	Бургастай	Төмрийн хүдрийн баяжмал	1 150.6
4	Байтаг	Нүүрс	56.002
5	Гашуун сухайт	Нүүрс	17 240.3
		Зэсийн баяжмал	652.189
6	Ханги	Нүүрс	1 114.3
		Хүдэр	11.646
7	Шивээхүрэн	Нүүрс	10 479.1
8	Ярант	Нүүрс	452.963
Нийт			32,314,277.2

5.ТЭЭВРИЙН ХЭРЭГЛИЙН БҮРТГЭЛ

Монгол Улсад 2000 онд 81 693 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байсан бол 17 жилийн дараа буюу 2017 онд 900 125 автомашин болон өсчээ.




2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад нийт 900125 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 512003 буюу 56.8% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.



Нийт бүртгэгдсэн тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл суудлын автомашин 586 854 буюу 65%-ийг, ачааны автомашин 182 155 буюу 20 %, мотоцикл 48 203 буюу 5 %, автобус 6 859 буюу 1% ,тусгай зориулалтын 1 509 буюу 2 %, чиргүүл 25 596 буюу 3 % , механизм 11 335 буюу 1 % , бусад тээврийн хэрэгсэл 2,7%-ийг тус тус эзэлж байна.

2017 оны байдлаар нийт 61926 автомашин, 9741 механизм ипортоор орж ирсэн байна.



Жил ирэх тусам тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор шилжилт хөдөлгөөн ихсэж байна. 2017 оны байдлаар 57 974 тээврийн хэрэгслийг шинээр бүртгэн улсын дугаар олгож, 300 057 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг бүртгэсэн.







Монгол улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийг хүрдний байрлалаар ойролцоо байгаа боловч суудлын автомашины 206877 буюу 35.4% нь зүүн, 380004 буюу 64.6% нь баруун байна.



2017 оны байдлаар монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлаар авч үзвэл 0-3 жил ашиглагдаж буй 18840 буюу 2%, 4-6 жил ашиглагдсан 42882 буюу 5%, 7-9 жил ашиглагдсан 93344 буюу 10%, 10 ба түүнээс дээш жил ашиглагдсан 745059 буюу 73% -ийг тус тус эзэлж байна.




Монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдээс TOYOTA PRUIS маркийн автомашин хамгийн их буюу 105939 байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 12%-ийг бүрдүүлж байна.

Нийт тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөдөлгүүрийн төрлөөр нь авч үзэхэд эко буюу хосолсон, цахилгаан, хийн хөдөлгүүртэй авто амшин 15%-ийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 85% нь бензин болон дизел хөдөлгүүртэй байна.


6. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ

2017 онд автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт 551 537 тээврийн хэрэгслийг 2012 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан 386 881 тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад 42.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.






2017 оны дүн мэдээнээс харахад нийт 12071 тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй байгаагаас өнгө үзэмж 6487, жолооны механизм 3968, гэрлийн тохиргоо 3665, тоормос 2752, утаа 1558, дуу чимээний түвшингээр 104 тээврийн хэрэгсэл тус тус тэнцээгүй байна.

Техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 54.01% -ийг өнөг үзэмжээр тэнцээгүй тээврийн хэрэгсэл эзэлж байна.



7.МЭРГЭШСЭН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ


2017 оны байдлаар В ангилалтай 10631, С ангилалтай 5331, Д ангилалтай 16417, Е ангилалтай 20550 мэргэшсэн жолооч бэлтгэдээд байгаа бөгөөд мэргэшил дээшлүүлэх сургалтанд Улс хоорондын ачаа тээвэрлэлтээс мэргэшил дээшлүүлсэн - 11663, Улс хоорондын зорчигч тээвэрлэлтээр мэргэшил дээшлүүлсэн-914, Аюултай ачаа болон овор ихтэй, урт, хүнд ачаа тээвэрлэлтээр - 1495, Жуулчин тээвэрлэлтээр мэргэшил дээшлүүлсэн - 2188 байна. Нийт 49079 мэргэшсэн жолооч бүртгэлтэй байна.





8. АВТО ҮЙЛЧИЛГЭЭ

Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээг, засвар хийх журам”-уудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд доорх Улаанбаатар хотод 33, хөдөө орон нутагт 122 аж ахуйн нэгжүүд ангилал тогтоосон байна.



9. ЗАМ, ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ

Монгол улсын хэмжээнд 2017 онд 36591 зам тээврийн осол бүртгэгдсэний 32662 буюу 89,3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Орон нутагт 3929 зам тээврийн осол бүртгэгдсэн байна.

Зам тээврийн ослыг эд материалын хохиролтой ба хүн гэмтсэн зам тээврийн осол гэж ангилан бүртгэлд авч байна.

Эд материалын хохиролтой зам тээврийн осол - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзэж байна.

Хүн гэмтсэн осол-зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзэж байна.


ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Нутаг дэвсгэр	Зам тээврийн осол		
		2017	Өссөн, буурсан тоо	Өссөн буурсан хувь
1	Хан-Уул дүүрэг	5373	-136	-2.5
2	Баянгол дүүрэг	6241	-1885	-23.2
3	Баянзүрх дүүрэг	7285	-2168	-22.9
4	Сүхбаатар дүүрэг	4487	-2498	-35.8
5	Сонгинохайрхан дүүрэг	5189	-1404	-21.3
6	Чингэлтэй дүүрэг	3797	-627	-14.2
7	Багануур дүүрэг	147	-50	-25.4
8	Багахангай дүүрэг	12	2	20.0
9	Налайх дүүрэг	131	53	67.9

Улсын хэмжээнд 36591 зам тээврийн осол бүртгэн шалгасны 88,8 хувь нь эд материалын хохиролтой осол байхад 11,2 хувь нь гэмтсэн /хүний амь нас, эрүүл мэнд хохирсон /зам тээврийн осол байна.

10. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниуд 2017 онд 605,679 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 29,008,226,904 төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон байна. Даатгалын гэрээний хувьд ангиллаар авч үзвэл хувь хүний 465,791 хуулийн этгээдийн 119,607 , мэргэшсэн болон СД ангиллын жолоочийн 13,488 дамжин өнгөрөхийн 6,793 гэрээ байгуулагдсан байна. Жолоочийн даатгалд хамрагдалтыг доохи хүснэгтэд харуулвал:



ХАВСРАЛТ

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, чиглэлийн дугаар, нэр, тээвэрлэлт гүйцэтгэж буй нийт тээврийн хэрэгслийг тоог доорх хүснэгтэд үзүүлэв.

Д/д	ААНБ-ын нэр	Чиглэлийн дугаар	Чиглэлийн нэр	Т/Х-ийн тоо
-----	-------------	------------------	---------------	-------------

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ

1	Зорчигч тээврийн нэгтгэл 1-р бааз	8	"Зайсан - Цэцэг төв - Хайлааст"	14	
		9	"Нисэх - Нарны гүүр - Тэнгис кинотеатр - Хүнсний 4 дэлгүүр"	13	
		14	"Нарангийн гол - 10-р хороолол"	10	
		15	"Нисэх - Сонсголон - 5 шар - 3 -р эмнэлэг"	10	
		23	"Чингэлтэй- Зүрх уул - МУБИС - Цэцэг төв"	10	
		26	"Тоосгоны үйлдвэр - Ботаник - Жанжин клуб"	9	
		43	"Баянхошуу - Ард кинотеатр - ТЭЦ 3"	13	
		50	"БММЗ - Улаанхуаран"	13	
		56	Буянт ухаа-2 хороолол-120 мянгат	5	
		58	"3.4 хороолол - БММЗ"	14	
		59	"ХМК-Офицеруудын ордон"	8	
		61	Офицеруудын ордон-МУБИС-120 мянгат-Алтай хотхон-Мишээл экспо	2	
		63	Хан хиллс хотхон-Ривер гарден-Баянмонгол хороолол-МУБИС-Ард кино театр	2	
		ХО6	"Өлзийт хороолол - 120 мянгат"	2	
		ХО7	"Туул тосгон - Биокомбинат - 120 мянгат"	4	
	Зорчигч тээврийн нэгтгэл 2-р бааз /Их багтаамж/	1	"5 шар - Офицеруудын ордон" /угсраа/	16	
		59	"ХМК-Офицеруудын ордон "	14	
		т2	"5 шар - Ботаник"	17	
		т5	"3. 4 хороолол - Офицеруудын ордон"	10	
		ХО10	Эмээлт /хурган/ - Хархорин - 10-р хороолол	2	
	Зорчигч тээврийн нэгтгэл 3-р бааз	11	"Хужирбулан - Офицеруудын ордон"	6	
		25	"Тоосгоны үйлдвэр - Их тойруу - 3,4 хороолол"	13	
		28	"Сэлх - 7 буудал-Ард кино театр"	9	
		29	"Сэлбэ амралт - МУБИС - Вокзал"	19	
		32	"Улиастай - Баянмонгол хороолол - ТЭЦ 3"	14	
		57	"Улаанчулуут -Их наран - МУИС"	16	
	Зорчигч тээврийн нэгтгэл 2-р бааз /дунд багтаамж/	63	Хан хиллс хотхон-Ривер гарден-Баянмонгол хороолол-МУБИС-Ард кино театр	6	
		12	"Ургах наран хороолол - Офицеруудын ордон"	6	
		60	"Авто худалдааны цогцолбор - Саппоро"	1	
		ХО1	"Бага баян - Санзай - 7 буудал - Тэнгис кино театр"	4	
		ХО8	"Найрамдал зуслан - Саппоро - 3-р эмнэлэг"	2	
		ХО9	"Био комбинат - Сонсголон - 5 шар"	4	
		ХО11	"Хонхор - Офицеруудын ордон- ХӨСҮТ"	3	
		ХО12	"Мал бордох - 5 шар - Саппоро"	2	
	ХО13	"Баруун түрүү - 10 хороолол"	2		
	Зорчигч тээврийн нэгтгэлийн нийт дүн				295

2	"Блюбус" ХХК	40	"Мах импекс - Тэнгискинотеатр - Улаанхуаран"	23
		24А	"Зунжин - Сонсголон - ТЭЦ 4"	7
3	"Сутайн буянт" ХХК	18А	"3,4 хороолол - Ард кинотеатр - ТЭЦ 3" /Баруунтойрог/	7
		21А	"Булгын 19-р гудамж - Вокзал - 3,4 хороолол"	6
		38	"ХМК - Саппоро - 3,4 хороолол - Хайлааст"	14
		46	"Улаан чулуут - Их наран - Вокзал"	10
		49	"1-р хороолол - Модны 2 - МУИС - Дунжингарав худалдааны төв"	16
		61	Офицеруудын ордон-МУБИС-120 мянгат-Алтай хотхон-Мишээл экспо	8
		ШҮ1	"5 шар-Ботаник"	4
4	"Автобус нэгдэл" ХХК	3	"Зүүн салаа - Халдвартын эмнэлэг"	11
		20А	"Баянхошуу - 3,4 хороолол - Өнөр хороолол-/араар/ Геологийн төв лаборатори"	8
5	"Мяралаа" ХХК	30А	"Жанжин клуб - Зүүн 4 зам-МУБИС - Ард кино театр"	6
		30Б	"Жанжин клуб - Дамдинсүрэнгийн гудамж- МУБИС - Ард кино театр"	6
		34	Шар хад-Сансар-Ард кино театр-ТЭЦ3	18
6	"Мон кара" ХХК	17А	"Баруун 4 зам - Их тойруу - Зүүн 4 зам - Нарны зам" /их тойрог/	6
		17Б	"Баруун 4 зам - Нарны зам - Зүүн 4 зам - Их тойруу" /их тойрог/	6
		55	"Зайсан - Дэнжийн 1000 - ЗГАБааз - Согоотын гудамж"	15
7	"Тэнүүн Огоо" ХХК	2	"Шархад - МУБИС - 3,4 -р хороолол"	20
		4	"5 шар - 3,4 -р хороолол - Сансарын тойрог"	12
		13	"Тахилт - Саппоро-3-р эмнэлэг"	12
		22	"Шадивлан -Бөмбөгөр - Чингис Соосэ ДС-Далангийн зам"	13
		37	"Улаанхуаран - 4 хороолол"	11
		39	"Сансар - 3,4 хороолол"	10
		47	"Орбит - Ардкинотеатр"	18
		48	"Зүүн салаа - Чингэлтэй дүүрэг - МУБИС"	16
8	"Транс бус" ХХК	5	"Гэмтлийн эмнэлэг - Их тойруу - Шар хад"	18
		19Б	"Монелийн 43 - Сансар - Офицеруудын ордон" /зүүн тойрог/	5
9	"Атибус" ХХК	42	"Сүлжмэл - Нарны гүүр - Зайсан"	11
		51	"3,4 хороолол - МУИС - Дунжингарав худалдааны төв"	11
		52	"3,4 хороолол-Тэнгис к/т- Зайсан"	7
		ХО5	"Налайх - Зүүн 4 зам - МУБИС"	7
10	"Эрдэм транс" ХХК	3	"Зүүн салаа - Халдвартын эмнэлэг"	19
		6	"Толгойт - Нарны зам - Ботаник"	20
		18Б	"3,4 хороолол -ТЭЦ 3 -Цэцэг төв" (Баруун тойрог)	7
		20Б	"Баянхошуу - ГТЛаборатори - Өнөр хороолол - 3,4 хороолол"	9
		21Б	"Булгын 19-р гудамж - 3,4 хороолол - Вокзал"	6
		24Б	Зүрх уул-Гурвалжингийн гүүр-ТЭЦ4	7
		44	"Нарангийн гол - ТЭЦ 3 - Дунжингарав худалдааны төв"	13
		53	"Яармаг - МУБИС "	11
		54	"Яармаг - 10 хороолол - 3,4 хороолол - Зурагт"	11
		ХО2	"Шарга морьт - Дунжингарав худалдааны төв"	11
64	"Цагаан даваа - Офицеруудын ордон- Монгол кино үйлдвэр"	3		

11	"ДЮЦ" ХХК	19А	"Монелийн 43 - Офицеруудын ордон - Сансар" /зүүн тойрог/	5
		35	"Монелийн 43-Хүнсний 4 -р дэлгүүр-МУИС-11 хороолол"	8
		ХО4	"Тэрэлж - Мэлхий хад-Налайх - Баруун 4 зам"	1
12	"Морь барьдаг" ХХК	ХО3	"Городок - Дүнжингарав худалдааны төв"	2
		ХО5	"Налайх - Зүүн 4 зам - МУБИС"	15
13	"Тэнүүндэлгэр" ХХК	24А	"Зунжин - Сонсголон - ТЭЦ 4"	4
14	"ЭМСИД" ХХК	31	"Улиастай - Баянбүрд - Зам гүүрийн автобааз"	18
		36	"Гачуурт - Офицеруудын ордон - Зайсан"	14
15	"Сайхан ирээдүй" ХХК	27	"Вокзал - Бөмбөгөр - Өвөр согоот"	14
16	"ГБУС" ХХК	45	"Ган хийц - ХМК - Зайсан"	15
17	"НЦБ" ХХК	16	"Баруун салаа-Далангийн зам-10-р хороолол"	9
		41	"Баруун салаа - Их тойруу - Халдвартын эмнэлэг"	10
18	"Аз сервис" ХХК	т4	"Ботаник - Вокзал"	6
19	"Автотерминал трейд" ХХК	7	"Нисэх - Төв номын сан - 7 буудал-Зунжин"	23
		24А	"Зунжин - Сонсголон - ТЭЦ 4"	3
20	"Тэнүүн - Огоо" 3-р бааз ХХК	10	"Ганц худаг - Сансар - Баянмонгол хороолол -Мишээл экспо /Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв"	11
		22	"Шадивлан -Бөмбөгөр - Чингис Соосэ ДС-Далангийн зам"	5
		33	"Шархад - 7 буудал - Зунжин худалдааны төв"	12
21	"Эс Энд Эй" ХХК	62	"Алтан овоо 42-р гудамж/СХД 26-р хороо/-Саппоро-10-р хороолол"	8
Хувийн хэвшлийн компанийн нийт дүн				642
НИЙТ ДҮН				937

Нийтийн тээврийн буухиа үйлчилгээ

1	"Хөлөг налайх" хоршоо	24	Налайх - Дүнжингарав	12
2	Бичил аян хоршоо	БҮ:1	Бэлхийн хуучин эцэс-сансар	4
		БҮ:2	БЗД 21 дүгээр хороо Сансар	3
		БҮ:3	Нисэх-Нисэхийн дэнж-	5
		БҮ:4	Яармаг	4
		БҮ:5	Булгийн 20-р гудамж ЗГАБ	4
		БҮ:6	3,4-р хороолол	4
		БҮ:7	410-р худаг хайлааст	12
		БҮ:8	Ган хийц ХМК	3
		БҮ:9	Өндөр дэнж- Хархорин	4
		БҮ:10	Зүрх уул-Чингэлтэй	11
		БҮ:11	Шархад	4
		БҮ:12	Монел 38-Чулуун овоо	6
		БҮ:13	Цагаан даваа-Чулуун овоо	4
		БҮ:14	Баянхошуу-Гандан	4
		БҮ:15	Улиастай	5
		БҮ:16	Нарангийн гол	4
Нийт тээврийн хэрэгслийн тоо				93

Нийтийн тээврийн туслах шугамын үйлчилгээ

1	"Шинэ Уул" ХХК	ТШ-3	Энх цаг хүнсний дэлгүүр-СХД-31-р хороо	2
2	"Өндөр буянт" ХХК	ТШ-7	БГД-н 10-р хороо-Хасбаатарын гудамж	2
3	"Үнэгтийн уул" ХХК	ТШ-9	Цагаан даваа-Гандан-Вокзал /Дунд багтаамж/	3
4	"Дэн- Оюу" ХХК	ТШ-13	СХД-н Алтан-Овооны 44-р гудамж-БГД-н 23-р хороо	5
5	"Буурал мянган" ХХК	ХО	Жаргалант тосгон-361-р гарам-Хархорин зах	4
Нийт тээврийн хэрэгслийн тоо				16

ХОТ ХООРОНДЫН НИЙТИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛ

д/д	Чиглэлийн дугаар	Чиглэлийн нэр	Чиглэлийн урт /км/
1.	ХХ01	Улаанбаатар хот – Архангай аймгийн Эрдэнэбулган сум	486
2.	ХХ02	Улаанбаатар хот – Баян-Өлгий аймгийн Өлгий сум	1709
3.	ХХ03	Улаанбаатар хот – Баянхонгор аймгийн Баянхонгор сум	640
4.	ХХ04	Улаанбаатар хот – Булган аймгийн Булган сум	438
5.	ХХ05	Улаанбаатар хот – Говь-Алтай аймгийн Есөн булаг сум	1037
6.	ХХ06	Улаанбаатар хот – Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум	223
7.	ХХ07	Улаанбаатар хот – Дархан-Уул аймгийн Дархан сум	219
8.	ХХ08	Улаанбаатар хот – Дорноговь аймгийн Сайншанд сум	450
9.	ХХ09	Улаанбаатар хот – Дорнод аймгийн Хэрлэн сум	662
10.	ХХ10	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Сайнцагаан сум	275
11.	ХХ11	Улаанбаатар хот – Завхан аймгийн Улиастай сум	1023
12.	ХХ12	Улаанбаатар хот – Орхон аймгийн Баян-Өндөр сум	378
13.	ХХ13	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Арвайхээр сум	431
14.	ХХ14	Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Даланзадгад сум	575
15.	ХХ15	Улаанбаатар хот – Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум	565
16.	ХХ16	Улаанбаатар хот – Төв аймгийн Зуунмод сум	43
17.	ХХ17	Улаанбаатар хот – Увс аймгийн Улаангом сум	1382
18.	ХХ18	Улаанбаатар хот – Ховд аймгийн Жаргалант сум	1488
19.	ХХ19	Улаанбаатар хот – Хөвсгөл аймгийн Мөрөн сум	788
20.	ХХ20	Улаанбаатар хот – Хэнтий аймгийн Өндөрхаан сум	338
21.	ХХ21	Улаанбаатар хот – Архангай аймгийн Цэцэрлэг сум	560
22.	ХХ22	Улаанбаатар хот – Архангай аймгийн Чулуут сум	610
23.	ХХ23	Улаанбаатар хот – Архангай аймгийн Тариат сум	647
24.	ХХ24	Улаанбаатар хот – Архангай аймгийн Жаргалант сум	571
25.	ХХ25	Улаанбаатар хот – Архангай аймгийн Эрдэнэмандал сум	511
26.	ХХ26	Улаанбаатар хот – Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Шаргалжуут баг	643
27.	ХХ27	Улаанбаатар хот – Булган аймгийн Гурванбулаг сум	296
28.	ХХ28	Улаанбаатар хот – Дархан-Уул аймгийн Шарын гол сум	209
29.	ХХ29	Улаанбаатар хот – Дорноговь аймгийн Замын-Үүд сум	662
30.	ХХ30	Улаанбаатар хот – Дорнод аймгийн Дашбалбар сум	756
31.	ХХ31	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Адаацаг сум	211
32.	ХХ32	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Эрдэнэдалай сум	274
33.	ХХ33	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Сайхан овоо сум	505
34.	ХХ34	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Гурвансайхан сум	322
35.	ХХ35	Улаанбаатар хот – Дундговь аймгийн Мандалговь, Эрдэнэдалай сум	389
36.	ХХ36	Улаанбаатар хот – Завхан аймгийн Тосонцэнгэл сум	838
37.	ХХ37	Улаанбаатар хот – Завхан аймгийн Сонгино сум	1037
38.	ХХ38	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Бүрд сум	332
39.	ХХ39	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Хужирт сум	384
40.	ХХ40	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Есөн зүйл сум	368
41.	ХХ41	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Хархорин сум	365
42.	ХХ42	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Сант сум	409
43.	ХХ43	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум	433
44.	ХХ44	Улаанбаатар хот – Өвөрхангай аймгийн Богд сум	628
45.	ХХ45	Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад баг	740
46.	ХХ46	Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Цогтцэций сум	541
47.	ХХ47	Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Гурван тэс сум	876
48.	ХХ48	Улаанбаатар хот – Сүхбаатар аймгийн Дарьганга сум	710
49.	ХХ49	Улаанбаатар хот – Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум	768
50.	ХХ50	Улаанбаатар хот – Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум	343
51.	ХХ51	Улаанбаатар хот – Сэлэнгэ аймгийн Мандал сум	184
52.	ХХ52	Улаанбаатар хот – Төв аймгийн Алтанбулаг сум	51
53.	ХХ53	Улаанбаатар хот – Төв аймгийн Баянжаргалан сум	161
54.	ХХ54	Улаанбаатар хот – Төв аймгийн Баян сум	98

55.	ХХ55	Улаанбаатар хот – Төв аймгийн Жаргалант сум	128
56.	ХХ56	Улаанбаатар хот – Төв аймгийн Заамар сум	183
57.	ХХ57	Улаанбаатар хот – Төв аймгийн Угтаалцайдам сум	156
58.	ХХ58	Улаанбаатар хот – Төв аймгийн Цээл сум	179
59.	ХХ59	Улаанбаатар хот – Төв аймгийн Шижир алт сум	260
60.	ХХ60	Улаанбаатар хот – Төв аймгийн Батсүмбэр сум	79
61.	ХХ61	Улаанбаатар хот – Төв аймгийн Өндөр ширээт сум	188
62.	ХХ62	Улаанбаатар хот – Увс аймгийн Ховд сум	1464
63.	ХХ63	Улаанбаатар хот – Увс аймгийн Зүүнговь сум	1280
64.	ХХ64	Улаанбаатар хот – Увс аймгийн Өндөрхангай сум	1148
65.	ХХ65	Улаанбаатар хот – Ховд аймгийн Булган сум	1720
66.	ХХ66	Улаанбаатар хот – Хөвсгөл аймгийн Тариалан сум	648
67.	ХХ67	Улаанбаатар хот – Хөвсгөл аймгийн Галт сум	862
68.	ХХ68	Улаанбаатар хот – Хөвсгөл аймгийн Рашаант сум	547
69.	ХХ69	Улаанбаатар хот – Хэнтий аймгийн Баян-Адарга сум	456
70.	ХХ70	Улаанбаатар хот – Хэнтий аймгийн Батширээт сум	407
71.	ХХ71	Улаанбаатар хот – Хэнтий аймгийн Батноров сум	443
72.	ХХ72	Улаанбаатар хот – Хэнтий аймгийн Дархан сумын Бор өндөр баг	348
73.	ХХ73	Улаанбаатар хот – Улаанбаатар хотын Багануур дүүрэг	131
74.	ХХ74	Улаанбаатар хот – Улаанбаатар хотын Бага хангай дүүрэг	110

УЛС ХООРОНДЫН ЗОРЧИГЧДЫН ТОГТМОЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗӨВШӨӨРӨЛ

Эрх бүхий байгууллагаас улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэрлэлтийн зөвшөөрөл авсан дараах байгууллагууд “АТҮТ” ТӨҮГ-тай тээвэрлэлтийн гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Үүнд:

1. Дэлгэрэх тээх ХХК (МУ), АТҮТ (МУ), Юань Шүнь ХХК (БНХАУ) Монгол Улсын Замын-Үүд сумаас Замын-Үүд-Эрээн боомтоор БНХАУ-ын Эрээн хотын чиглэлд ,
2. Юань Шүнь ХХК (БНХАУ), Жиу Лун Сян Хө ХХК (БНХАУ) Монгол Улсын Замын-Үүд сумаас Замын-Үүд-Эрээн боомтоор БНХАУ-ын Бээжин хотын чиглэлд,
3. Юань Шүнь ХХК(БНХАУ) Монгол Улсын Замын-Үүд сумаас Замын-Үүд-Эрээн боомтоор БНХАУ-ын Хөх хотын чиглэлд,
4. Нью Жуулчин Турс ХХК (МУ), Восток транс ХХК (ОХУ) Монгол Улсын Улаанбаатар хотоос Алтанбулаг-Хиагт боомтоор ОХУ-ын Улаан-Үүд хотын чиглэлд,
5. Зэлтэрийн Зам ХХК (МУ), Восток транс ХХК (ОХУ) Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Сухбаатар сумаас Аланбулаг-Хиагт боомтоор ОХУ-ын Хиагт хотын чиглэлд,
6. Зэлтэрийн зам ХХК (МУ), АБИ ХХК (БНКазУ) Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Өлгий сумаас Цагааннуур-Ташанта боомтоор БНКазУ-ын Караганда хотын чиглэлд:
7. Түмэнд Нээлттэй Хязгаарынхан ХХК (МУ) Монгол Улсын Увс аймгийн Улаангом сумаас Боршоо-Хандгайт боомтоор ОХУ-ын Кызыл хотын чиглэлд:
8. “Атибус” ХХК, “Тэнүүн огоо” ХХК, “Эрдэм транс” ХХК МУ-ын нийслэл Улаанбаатар хотоос БНХАУ-ын Эрээн хот чиглэлд;

оОо